



## **“МАЛ ЭМНЭЛГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ, УДИРДЛАГЫН СИСТЕМ”-ИЙН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАН АЖИЛЛАН СУРГАЛТЫН КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ ХАМТРАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ УРИЛГА**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/385 дугаар тушаалаар батлагдсан “Төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалт явуулах болон малын эмчид итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах журам”-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд хөгжүүлэгдсэн “МАЛ ЭМНЭЛГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ, УДИРДЛАГЫН СИСТЕМ” (МЭХНХУС)-ийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллан сургалтын комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах байгууллагыг сонгон шалгаруулж, хамтран ажиллана.

### **Гүйцэтгэх ажил:**

- МЭХНХУС-ийн хэвийн, тогтвортой, ил тод, аюулгүй үйл ажиллагааг тасралтгүй хангах
- Системд “Сургалтын комисс”-ын зөвшөөрлөөр холбогдох мэдээллийг шаардлагатай хугацаанд байршуулах;
- Системд шаардлагатай хөгжүүлэлт хийх, сайжруулах санал боловсруулах, санаачилгатай ажиллах;
- Системд шаардлагатай цэс(сургалтын модуль, шалгалтын тестийн сан, шалгалт авах, асуумж судалгаа авах зэрэг)-ийг үүсгэх, үр дүнг сургалтын комисст тухай бүр мэдээлэх;
- Хэрэглэгчдийн бүртгэлийг баяжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх;
- Системийг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, сургалтын комисс, сургалт эрхлэх байгууллагатай хамтран ажиллах;
- Системийн хэрэглэгчдийг нэмэгдүүлэх, бүртгэлийг баяжуулах, мэдээллийн бодит байдалд дүгнэлт хийх, зохих хэрэглэгчийг бүрэн бүртгүүлэх, хэрэглэгчдийг цахим систем ашиглах заавар, зөвлөмжөөр хангах;
- Системийн ашиглалт, хөгжүүлэлт, гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайланг заасан хугацаанд нь Сургалтын комисст тайлагнах;
- Хэрэглэгчийн санал, гомдлын дагуу хяналт, үнэлгээ хийж тайлан, дүгнэлтийг Сургалтын комиссоор хэлэлцүүлэх;
- Сургалтын комисстой хамтран уулзалт, семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах.
- Үргэлжилсэн сургалт зохион байгуулах болон шалгалт авах үйл ажиллагаанд явцын хяналт тавих, үр дүнг тухай бүрд Сургалтын комисст тайлагнах;
- Сургагч багш нарын арга зүйн чадварыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах

### **Тавигдах шаардлага:**

- Албан ёсны гэрчилгээ бүхий хуулийн этгээд байх;
- Мал эмнэлгийн боловсролын /төгсөлтийн дараах сургалт/ болон мэдээллийн системийн чиглэлээр мэргэшсэн, чадвартай хүний нөөцтэй байх;
- Тухайн цахим системийг ажиллуулах техник хангамж, мэдээллийн технологийн хангалттай нөөцтэй байх /зөөврийн болон суурин суурин компьютер бусад техник хангамж/;
- Дижитал хэлбэрээр мэдээлэл цуглуулах, сан бүрдүүлэх, судалгаа хийх талаар ижил төстэй ажил хийж байсан ажлын туршлагатай байх;

- 3-аас доошгүй жил цахим болон танхимын сургалт зохион байгуулсан туршлагатай байх;
- Системийн аюулгүй ажиллагааг тасралтгүй хангах, ажлыг цаг тухайд хэрэгжүүлж, хүлээлгэн өгөх өндөр хариуцлага, чадавхтай байх;
- Судалгааны тайлан, мэдээллийг чанартай бэлтгэх чадвар, туршлагатай байх;
- Мал эмнэлгийн үргэлжилсэн сургалт /багц цагийн болон итгэмжлэлийн/ явуулах чиг үүргээс татгалзах саналыг хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлсэн байх.

#### **Бүрдүүлэх материал:**

- Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Уг даалгаварт заасан ажлыг удирдан чиглүүлэх багийн ахлагчийн танилцуулга
- Багийн гишүүдийн танилцуулга /5-аас доошгүй/
- Төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалт хийж байсан туршлагыг нотлох 3 хүртэлх гэрээний хуулбар, захиалагчтай холбоо барих мэдээлэл, эсхүл сургалтын тайлан
- Тавигдах шаардлагад заасан шаардлагыг нотлох баримт бичгүүд /гэрээ, тоног төхөөрөмж, фото зураг/
- Мал эмнэлгийн үргэлжилсэн сургалт /багц цагийн болон итгэмжлэлийн/ явуулах чиг үүргээс татгалзах саналыг хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлсэн албан бичиг

#### **Анхаарах зүйлс:**

- Баримт бичгийг битүүмжилсэн байх ба дугтуйн гадна талд “Мал эмнэлгийн ерөнхий газар, Сургалтын комисст” гэж хаяглан, сонгон шалгаруулалтад оролцогч байгууллагын хаяг, холбоо барих утасны дугаарыг гаргацтай бичнэ.
- Баримт бичгийг сонгон шалгаруулалтын дараа буцаан олгохгүй.
- Хугацаа хоцорсон баримт бичгийг хүлээн авахаас татгалзана.
- Баримт бичгийн бүрдэл дутуу тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасна.
- Сонгон шалгаруулалтаар шаардлага хангасан зөвхөн 1 байгууллагатай гэрээ байгуулна.

#### **Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах хугацаа, газар:**

Сонирхсон этгээд материалаа хэвлэн, дугтуйлж дор дурдсан хаягаар **2024** оны **4** дүгээр сарын **17**-ны өдрийн **10:30** цагаас өмнө Мал эмнэлгийн ерөнхий газарт албан бичгийн хамт ирүүлэх ба, цахим хувилбарыг [trainingcommission@vet.gov.mn](mailto:trainingcommission@vet.gov.mn) хаягаар мөн хугацааны дотор ирүүлнэ.

#### **Хаяг:**

Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр

**МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**